



БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2024 оны 04 сарын 24 өдөр

Дугаар А/280

Булган сум

Гэрээ байгуулах эрх олгох тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.5.2, 60 дугаар зүйлийн 60.1.5, 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 61 дүгээр зүйлийн 61.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Булган аймгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын харьяа Сувиллын яслийн барилгыг аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны XXII/03 дугаар тогтоолоор акталж, улсын төсвийн хөрөнгө оруулалтаар шинээр барих болсонтой холбогдуулан тус яслийн үйл ажиллагааг 2024 оны 04 дүгээр сарын 17-ны өдрөөс 2024 оны 05 дугаар сарын 31-ний өдрийг дуустал “Булган-Анар” ХХК-ны 214м² талбай бүхий өргөтгөлийн барилгад шилжүүлэн, үйл ажиллагааг стандартын шаардлагад нийцүүлэн явуулахыг Сувиллын яслийн эрхлэгч (С.Мягмарсүрэн)-д үүрэг болгосугай.

2. “Булган-Анар” ХХК-ны өргөтгөлийн барилгын түрээсийн төлбөрийг сарын 3,000,000 (гурван сая) төгрөгөөр тооцож, түрээсийн гэрээ байгуулан, хяналт тавьж ажиллахыг Орон нутгийн өмчийн газрын дарга (Т.Баттулга)-д үүрэг болгосугай.

3. Тус цэцэрлэгийн барилгын түрээсийн зардлыг орон нутгийн төсвөөс шийдвэрлэн санхүүжүүлэхийг Санхүү, төрийн сангийн хэлтэс (Д.Батцогт)-т зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА

Б.АРИУН-ЭРДЭНЭ

